



## ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ, ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №10

### *Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол*

2025 оны 09 дүгээр сарын 01 нээс 10 дугаар сарын 03 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Өвчний сэжигтэй эсвэл үхсэн шувууд таарсан тохиолдолд: **ЗӨСҮТ-н 70282853** дугаарт эсвэл дараах холбоосоор мэдээлэл илгээнэ үү. <https://arcq.is/KXDjy>

### *Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл*

2025 оны 09 дүгээр сарын 01 нээс 10 дугаар сарын 03 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн 4 тохиолдол бүртгэгдсэн.

БНХАУ-н шувууны аж ахуй ихтэй Сичуан, Чунчин, Анхуй, Хунан зэрэг мужид 1 настай хүү, 6 настай хүү, 2 настай хүү, 2 настай хүү сул хоруу чанартай шувууны томуугийн H9N2 хэвшинжээр өвчилсөн байна.

### *Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:*

2025 оны 09 дүгээр сарын 01 нээс 10 дугаар сарын 03 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус АНУ, Канад, Вьетнам, Өмнөд Солонгос, Польш, Испани, Португал, Унгар, Норвеги, Өмнөд Африк зэрэг 10 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 49 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Ихэвчлэн Хойд Америк тивийн улс оронд шувууны аж ахуй, хөхтөн амьтад, Европ тивийн улс оронд нүүдлийн шувууд, Зүүн Азийн улс оронд хүний болон өрхийн тэжээвэр шувуудын дунд өвчлөл бүртгэгдсэн.

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжийн тархалт

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

| Дэд хэвшинж | Улс            | Зүйлийн нэр                                  | Нийт тохиолдол |
|-------------|----------------|----------------------------------------------|----------------|
| H5N1        | АНУ            | Шувууны аж ахуй, муур, зурам, гэрийн хулгана | 14             |
| H5N1        | Канад          | Шувууны аж ахуй                              | 4              |
| H5N1        | Унгар          | Тураг гогой                                  | 2              |
| H5N1        | Польш          | Шувууны аж ахуй, хун                         | 5              |
| H5N1        | Норвеги        | Үнэг, цахлай, шувууны аж ахуй                | 7              |
| H5N1        | Португал       | Цахлай, шувууны аж ахуй                      | 6              |
| H5N1        | Өмнөд Африк    | Шувууны аж ахуй, цахлай                      | 3              |
| H5N1        | Өмнөд Солонгос | Шувууны аж ахуй                              | 1              |

|      |         |                                |   |
|------|---------|--------------------------------|---|
| H5N1 | Испани  | Нугас, галуу, шувууны аж ахуй  | 3 |
| H5N1 | Вьетнам | Шувууны аж ахуй /тахиа, нугас/ | 4 |

Зураг 1. 2025 оны 09 дүгээр сарын 01 нээс 10 дугаар сарын 03 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт

